

# *Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгглээ*

---

ШҮҮХИЙН ШИЙДВЭРТ ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ НЬ

## Сургалтын агуулга

- Монгол Улсын эрүүгийн хуулийн 22 дугаар зүйлд заасан авлигын гэмт хэрэг үйлдэгдсэн байж болзошгүй тохиолдлыг шинжлэн судлах
- Суралцагч нар тохиолдол(2)-г уншиж танилцан ЭХ-ийн 22 дугаар зүйлийн тохирох хэсгээс зүйлчлэл хийж хэлэлцүүлэг өрнүүлэх
- МУ-ын Дээд шүүхийн 2022 оны 82 дугаар тогтоолыг уншиж танилцан дараагийн сургалтын удиртгал хэсэгт мэтгэлцээн өрнүүлэх

## Тохиолдол 1

Д нь нийтийн албан тушаалтан буюу Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн Санхүү, бүртгэлийн тасгийн дарга, ахлах нягтлан бодогчоор ажиллаж байх хугацаандаа өөрийн танил Л-гийн”Ажилгүйдлийн тэтгэмж авах” хүсэлтийн дагуу албаны нөлөөгөө ашиглан хамт ажилладаг М гэгчээр цохолт хийлгэж, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль, холбогдох журмыг зөрчиж, тэтгэмж авах эрхгүй этгээдэд болох Л-д тэтгэмжийн 3,710,352 олгохоор шийдвэрлүүлжээ.

## Асуулт:

Б.Д нь С.Л-ээс 370,000 төгрөг авсан бол ямар хариуцлага хүлээх вэ?

Б.Д нь С.Л-ээс мөнгө болон аливаа төрлийн шан аваагүй бол хариуцлага хүлээлгэх үү?

Шүүгдэгч Б.Д нь нийтийн албан тушаалтан буюу Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн Санхүү, бүртгэлийн тасгийн дарга, ахлах нягтлан бодогчоор ажиллаж байхдаа Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн зарим зүйл, хэсгийг зөрчиж, хэлтсийн орлого, шимтгэлийн байцаагч М-д албаны эрх нөлөөгөө ашиглан нөлөөлж, түүгээр тэтгэмжийн бичилтийг хийлгүүлж, холбогдох цахим санд шивүүлэн улмаар ажилгүйдлийн тэтгэмжийн тогтоолын хуудас болон тэтгэмжийн мөнгө шилжүүлэх баримт зэрэг дээр гарын үсэг зурж, баталгаажуулан иргэн С.Л-гийн дансанд ажилгүйдлийн тэтгэмжийн 3,710,352 төгрөгийг шилжүүлэн түүнд давуу байдал бий болгосон нь тогтоогдсон тул Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжид хамаарч байх тул шүүхээс зохих ялыг оногдуулна.

## Тохиолдол 2

Замын-үүд сумын А нэртэй ТӨХК-ийн албан хэрэгцээнд шаардлагатай 500 төгрөгийн тоног төхөөрөмжийг гүйцэтгэх захирал Б гэгч нь тендер сонгон шалгаруулалт зохион байгуулахгүйгээр БНХАУ-ын Гуанжу хотоос худалдан авахдаа инженер С-ээс зөвлөгөө авчээ. Мөн дээрх шууд худалдан авалтыг компанийн ТУЗ-ийн дарга мэдэж байсан бөгөөд амаар зөвшөөрөл өгсөн байна. Худалдан авсан тоног төхөөрөмж нь МУ-д зарагдаж буй дундаж үнийн дүнгээс 1 хувиар үнэтэй байсан ба компанийн ТУЗ-ын дарга, Гүйцэтгэх захирал Б болон инженер С өөрт аливаа хэлбэрээр хөрөнгө мөнгө аваагүй завшаагүй байна.

Асуулт 1. Гүйцэтгэх захирал Б-д ямар хариуцлага хүлээлгэх вэ?

Асуулт 2. ТУЗ-ийн дарга энэ тохиолдолд хариуцлага хүлээх үндэслэлтэй юу?

Тохиолдол (2)-т өгөгдсөн нөхцөл, асуултуудын хүрээнд чиглүүлэгчээс нэмэлт мэдээлэл авч хууль, эрх зүйн актуудын хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлнэ үү.

Хэрэглэгдэхүүн:

1. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 22 дугаар зүйл
2. Төрийн өмчийн тухай хууль
3. Авлигын эсрэг хууль
4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох эрх зүйн актууд

*Дасгал ажил:*

Монгол Улсын дээд шүүхийн 2022 оны 82 дугаар тогтоолыг уншиж дүн шинжилгээ хийх

## УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ /Хэргийн товч/

2022 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 82

Д.С, Д.Б, Г.Д, Т.Б нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай

1.Д.С нь Д.Б-тэй бүлэглэн Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Г.Д-ын хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулан шалгаж байсан “2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо “Велла веста” хотхоны 700 дугаар байрны 1701 тоотод оршин суух гэртээ Н.У нь бусдад зодуулж, эрүүл мэндэд нь хүндэвтэр хохирол учирсан” үйлдэлтэй 191000792 дугаартай хэргийг өөрт ашигтай шийдвэрлүүлж давуу байдал бий болгох зорилгоор 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдөр 20,000,000 төгрөгийг Д.Б-өөр дамжуулан Сүхбаатар дүүргийн Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн дарга Т.Б-д 10,000,000 төгрөгийн,

Д.Б болон нийтийн албан тушаалтан Т.Б нартай бүлэглэн Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Г.Д-т 5,000,000 төгрөгийн хахууль тус тус өгөх гэмт хэргийг санаачлан зохион байгуулж, хамтран оролцсон,



2.Д.Б нь Д.С-тэй бүлэглэн, түүний зохион байгуулснаар Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Г.Д-ын хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулан шалгаж байсан “2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо “Велла веста” хотхоны 700 дугаар байрны 1701 тоотод оршин суух гэртээ Н.У нь бусдад зодуулж, эрүүл мэндэд нь хүндэвтэр хохирол учирсан” үйлдэлтэй 191000792 дугаартай хэргийг Д.С-д ашигтай шийдвэрлүүлж өөртөө давуу байдал бий болгох зорилгоор хахуульд өгүүлсэн 20,000,000 төгрөгөөс,

Сүхбаатар дүүрэг дэх цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн дарга Т.Б-д Хан-Уул дүүргийн Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн мөрдөгч Г.Д-тай урьд хамт ажиллаж байсан, түүнчлэн Сүхбаатар дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн даргын албан тушаалын нэр нөлөөг ашиглан, түүнд хууль бусаар нөлөөлж, Д.С-ийн ашиг сонирхлын үүднээс нийтийн албан тушаалтныг гүйцэтгэх ёсгүй үйлдлийг гүйцэтгүүлсэн буюу “Н.У бусдад зодуулсан” гэх хэрэг бүртгэлтийн 191000792 дугаартай хэргээс хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт болох Н.М-өөс гэрчийн мэдүүлэг авсан тэмдэглэл, хохирогч Н.У-ын биеийн гадна хэсгийг харуулсан 26 кадр фото зургийг устгуулж, хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлж давуу байдал олгуулсны хариуд 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдөр 10,000,000 төгрөгийг,

мөн нийтийн албан тушаалтан Т.Б-тай бүлэглэн, Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн мөрдөгч, цагдаагийн ахмад Г.Д-т албаны чиг үүрэг бүрэн эрх, албан тушаалын байдалтай нь холбогдуулан буюу “2019 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо “Велла веста” хотхоны 700 дугаар байрны 1701 тоотод оршин суух гэртээ Н.У нь бусдад зодуулж, эрүүл мэндэд нь хүндэвтэр хохирол учирсан” үйлдэлтэй 191000792 дугаартай хэргээс хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт болох Н.М-өөс гэрчийн мэдүүлэг авсан тэмдэглэл, хохирогч Н.У-ын биеийн гадна хэсэгт үүссэн гэмтлийг харуулсан 26 кадр фото зургийг устгуулж, хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлсний хариуд 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдөр 5,000,000 төгрөгийг хахуульд өгсөн,

Д.Б-с 2019 оны 5 дугаар сард Д.С-гээс хууль бус үйл ажиллагаанд зориулж хахууль өгөх гэмт хэрэгт зарцуулахаар түүнд шилжүүлсэн 20,000,000 төгрөгөөс, зөрж гүйцэтгэн, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж, 5,000,000 төгрөгийг авч залилсан,

мөн 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдөр нийтийн албан тушаалтан Г.Д-тай бүлэглэн, Д.Сгийн ашиг сонирхлын үүднээс нийтийн албан тушаалтныг гүйцэтгэх ёсгүй үйлдлийг гүйцэтгүүлэх буюу “Н.У бусдад зодуулсан” гэх хэрэг бүртгэлтийн 191000792 дугаартай хэргийг хааж эцэслэн шийдвэрлүүлэхээр амлаж, дээрх үйлдлийг гүйцэтгэхийн тулд дахин 20,000,000 төгрөгийн хахууль өгөхийг шаардсан,

3.Шүүгдэгч Г.Д нь хууль сахиулагч буюу Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн мөрдөгчөөр ажиллаж байхдаа Сүхбаатар дүүрэг дэх Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн дарга Т.Б-тай бүлэглэн 2019 оны 5 дугаар сард өөрийн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байсан “Н.У бусдад зодуулсан” үйлдэлтэй хэрэг бүртгэлтийн 191000792 дугаартай хэргээс хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт болох Н.М-өөс гэрчийн мэдүүлэг авсан тэмдэглэл, хохирогч Н.У-ын биеийн гадна хэсгийг харуулсан 26 кадр фото зургийг устгасан,

Нийтийн албан тушаалтан буюу Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн мөрдөгчөөр ажиллаж байхдаа “Н.У бусдад зодуулсан” гэх хэрэг бүртгэлтийн 191000792 дугаартай хэргээс хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт болох Н.М-өөс гэрчийн мэдүүлэг авсан тэмдэглэл, хохирогч Н.У-ын биеийн гадна хэсгийг харуулсан 26 кадр фото зургийг устгаж, Д.С-ийн ашиг сонирхлын үүднээс гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийж, хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлсний хариуд Д.Б, Т.Б нараар дамжуулан, Д.С-ээс 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдөр 5,000,000 төгрөгийн хахууль авсан,

Д.Б-тэй бүлэглэн, 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдөр Д.С-ийн ашиг сонирхлын үүднээс нийтийн албан тушаалтныг гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхийн тулд буюу “Н.У бусдад зодуулсан” гэх хэрэг бүртгэлтийн 191000792 дугаартай хэргийг хаах шийдвэр гаргуулахаар мөрдөгчийн санал гаргасны хариуд урьд авсан 5,000,000 төгрөг дээр нэмж дахин 20,000,000 төгрөгийн хахууль өгөхийг шаардсан,

4.Т.Б нь Сүхбаатар дүүргийн Цагдаагийн нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн даргын албан тушаалтай, мөн Хан-Уул дүүрэг дэх Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн мөрдөгчөөр ажиллаж байсан Г.Д-тай урд Говь-Алтай аймгийн Цагдаагийн газарт хамт ажиллаж байсан давуу байдлаа ашиглан хууль бусаар нөлөөлж, түүний мөрдөн шалгах ажиллагаа явуулж байсан “Н.У бусдад зодуулсан” гэх хэрэг бүртгэлтийн 191000792 дугаартай хэргээс хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт болох Н.М-өөс гэрчийн мэдүүлэг авсан тэмдэглэл, хохирогч Н.У-ын биеийн гадна хэсгийг харуулсан 26 кадр фото зургийг устгуулахаар ятгаж, зааж зөвлөж, бусдыг гэмт хэрэг үйлдэхэд зориуд хүргэж, хатгасан,

Хан-Уул дүүргийн Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн мөрдөгч Г.Д-тай урьд хамт ажиллаж байсан, түүнчлэн Сүхбаатар дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн даргын албан тушаалын нэр нөлөөг ашиглан, түүнд хууль бусаар нөлөөлж, Д.С-ийн ашиг сонирхлын үүднээс нийтийн албан тушаалтныг гүйцэтгэх ёсгүй үйлдлийг гүйцэтгүүлсэн буюу “Н.У бусдад зодуулсан” гэх хэрэг бүртгэлтийн 191000792 дугаартай хэргээс хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт болох Н.М-өөс гэрчийн мэдүүлэг авсан тэмдэглэл, хохирогч Н.У-ын биеийн гадна хэсгийг харуулсан 26 кадр фото зургийг устгуулж, хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлж давуу байдал олгуулсны хариуд Д.Б-өөр дамжуулан Д.С-ээс 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдөр 10,000,000 төгрөгийн хахууль авсан,

Хан-Уул дүүргийн Цагдаагийн газрын нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн мөрдөгч Г.Д-тай урьд хамт ажиллаж байсан, түүнчлэн Сүхбаатар дүүргийн цагдаагийн нэгдүгээр хэлтсийн хэрэг бүртгэх тасгийн даргын албан тушаалын нэр нөлөөг ашиглан, түүнд хууль бусаар нөлөөлж, Д.С-ийн ашиг сонирхлын үүднээс нийтийн албан тушаалтныг гүйцэтгэх ёсгүй үйлдлийг гүйцэтгүүлсэн буюу “Н.У бусдад зодуулсан” гэх хэрэг бүртгэлтийн 191000792 дугаартай хэргээс хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримт болох Н.М-өөс гэрчийн мэдүүлэг авсан тэмдэглэл, хохирогч Н.У-ын биеийн гадна хэсгийг харуулсан 26 кадр фото зургийг устгуулж, хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлэх талаар нөлөөлж, давуу байдал олгуулсны хариуд, Д.С-ээс өөрт холбогдох хэргийг хаалгаж шийдвэрлүүлэх ашиг сонирхлын үүднээс Д.Б-өөр дамжуулан хахуульд өгсөн, 20,000,000 төгрөгөөс 5,000,000 төгрөгийг Д.Б-тэй хамт 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдөр мөрдөгч Г.Д-т дамжуулан өгч хахууль өгөх гэмт хэргийг үйлдэхэд хамтран оролцож, хамтран гүйцэтгэсэн гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Дараагийн сургалт нь “Ашиг сонирхлын зөвчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр үргэлжлэх бөгөөд хичээлийн удиртгал хэсэгт дээрх шүүхийн шийдвэрийн талаар санал бодлоо солилцоно уу.